



ДУНДГОВЬ АЙМАГ  
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/34

Тавин

Бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт, баталгаажуулах, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэлт хийх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6.6 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.2.3 дахь заалт, Хүнс Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/473 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэлт хийх ажлыг бог малын хээлтүүлэгч ялгасан 6 суурьт зохион байгуулсугай.

2. Тухайн ажлыг технологийн хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, стандартын шаардлага хангасан үржлийн малыг ялган тэмдэглэж, ажлын явцад хяналт тавьж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулж 2023 оны 10 дугаар сарын 20-ны дотор Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт холбогдох тайлан мэдээг нэгтгэх хүргэхийг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (О.Ганбаатар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.УРАНЧИМЭГ